

ХӨДӨЛМӨРИЙН САЙД, ХУУЛЬ ЗҮЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2015 оны 10 дүгээр сарын 05 өдөр

Дугаар А/158, А/218

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. "Жолоодох эрхийн шалгалтын төвийн үйл ажиллагааны журам"-ыг хавсралтаар баталсугай.


2. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Хууль зүйн сайдын 2014 оны А/158 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ХӨДӨЛМӨРИЙН САЙД



Г.БАЯРСАЙХАН

ХУУЛЬ ЗҮЙН САЙД



Д.ДОРЛИГЖАВ

Хөдөлмөрийн сайд, Хууль зүйн сайдын 2015 оны
10 дүгээр сарын 05 ны өдрийн 1181 /1618 дугаар
хамтарсан тушаалын хавсралт

ЖОЛООДОХ ЭРХИЙН ШАЛГАЛТЫН ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Жолоодох эрхийн шалгалтын төв /цаашид “шалгалтын төв” гэх/-ийн үйл ажиллагааг зохион байгуулахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Тээврийн хэрэгсэл жолоодох эрх олгох мэргэжлийн шалгалт /цаашид “шалгалт” гэх/-ыг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт заасан стандартын шаардлагыг хангасан шалгалтын төвд “Тээврийн хэрэгсэл жолоодох эрх олгох шалгалтын журам”-д заасан үйл ажиллагааг зохион байгуулна.

1.3.Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр аймаг тус бүрт нэг, нийслэлийн дүүрэг тус бүрт нэг шалгалтын төвийг байгуулна. Зарим дүүрэг дунд нэг шалгалтын төвийг байгуулж болно.

1.4.Шалгалтын төвийг нийслэлд Мэргэжлийн боловсрол, сургалтын бүсийн арга зүйн төв, орон нутагт Төрийн өмчийн Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг түшиглэн байгуулна.

1.5.Тухайн орон нутагт энэ журмын 1.4-т заасан байгууллага байхгүй бол төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагатай гэрээ байгуулан шалгалтын төвийг зохион байгуулж болно.

Хоёр.Шалгалтын төв, түүний үйл ажиллагаа

2.1.Шалгалтын төв нь холбогдох стандартын шаардлага хангасан бүртгэл, мэдээллийн нэгдсэн төв, онолын шалгалтын танхим болон жолоодлогын дадлагын шалгалтын гэрээт, эсхүл өөрийн талбайтай байна.

2.2.Шалгалтын төв дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.2.1.тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн онолын болон дадлагын шалгалтыг тасралтгүй байнгын ажиллагаатай тогтмол зохион байгуулах;

2.2.2.Монгол Улсын жолоодох эрхийн үнэмлэх олгох шалгалтад орох иргэдийн материалыг хянах, бүртгэх, шалгалтад хамрагдсан иргэдийн бүртгэл, мэдээллийн санг хөтлөх;

2.2.3.жолоодох эрх олгох шалгалтын хуваарь гаргаж, мэдээлэх;

2.2.4.шалгалтад тэнцсэн иргэдийн дүн мэдээг цагдаагийн байгууллагын тусгай зөвшөөрөл олгох ажил хариуцсан нэгжид мэдээллийн цахим сүлжээгээр буюу шаардлагатай тохиолдолд баталгаажуулсан хуудсаар хүргэх;

2.4.5.жолоодох эрхийн шалгалтад тэнцсэн иргэдийн хэвлэгдсэн жолоочийн үнэмлэхийг холбогдох албанаас авч, цахим хэлбэр /мэйл хаяг, мессеж үйлчилгээ/-ээр болон утсан холбоогоор мэдэгдэж, өөрт нь буюу итгэмжлэгдсэн этгээдэд хүлээлгэн өгөх.

Гурав. Онолын шалгалтын танхимд тавих шаардлага

3.1.Шалгалтын төв нь онолын шалгалтын хэд хэдэн танхимтай байж болно.

3.2.Онолын шалгалтын танхим нь дараах шаардлагыг хангасан байна:

3.2.1.дөч буюу түүнээс дээш шалгуулагч нэгэн зэрэг шалгалт өгөх бололцоо бүхий ширээ, сандалтай байх;

3.2.2.танхимын ариун цэвэр, гэрэлтүүлэг, агааржуулалт, орчны дуу чимээний түвшин холбогдох стандарт, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байх;

3.2.3.анхаарал сарниулах, чимээ шуугиан гаргах үзүүлэн, чимэглэл, тоног хэрэгсэл байрлуулаагүй байх;

3.2.4.шалгалтыг бичгээр авах тохиолдолд шалгуулагч нэг бүрт хүрэлцэхүйц тооны онолын тестийн материал, хариултын хүснэгтийн хуудастай байх;

3.2.5.шалгалтыг цахим төхөөрөмжөөр авах тохиолдолд шалгуулагч нэг бүрт хүрэлцэхүйц тооны компьютер, техник хангамжийн иж бүрэн системээр тоноглогдсон байх.

3.3.Онолын шалгалтын танхимд шалгагч болон шалгуулагчийн үйлдлийг хянах зориулалт бүхий дүрс бичлэгийн төхөөрөмж /камер/, мөн шалгалтын ил тод байдлыг хангах үүднээс цахим дэлгэцийг танхимын дотор ба гадна байрлуулна.

3.4.Онолын шалгалтыг цахим төхөөрөмжөөр явуулах тохиолдолд программ хангамж нь шалгуулагчаас компьютерийн нарийн мэдлэг шаардахгүй, шалгалт өгөх эрхийг хязгаарлахгүй, ашиглахад хялбар, ойлгомжтой байвал зохино.

Дөрөв. Дадлагын шалгалтын тусгай талбайд тавих шаардлага

4.1.Шалгалтын төв нь талбайн шалгалтыг явуулах хэд хэдэн тусгай талбайтай байж болно.

4.2.Дадлагын шалгалтын тусгай талбай нь дараах шаардлагыг хангасан байна.

4.2.1.талбайн хэмжээ нь тухайн ангиллын тээврийн хэрэгслээр гүйцэтгэвэл зохих үйлдлүүдийг хийх боломжийг хангахуйц байх;

4.2.2.орчны эрүүл ахуй, байгаль эколог, хөдөлгөөний аюулгүй байдлын техникийн норм, дүрэм, стандартын шаардлагад нийцсэн байх;

4.2.3.нийтийн эзэмшлийн зам, талбай, замын хөдөлгөөнөөс бүрэн тусгаарласан хаалт, хашаатай байх;

4.2.4.тээврийн хэрэгслээр зорчих хэсэг нь жигд хатуу хучилт, тэгш гадаргуутай байх;

4.2.5.тухайн ангиллын тээврийн хэрэгслээр шалгалт авахад нийцсэн хэмжээ, загвар бүхий жолоодлогын зохих үйлдлүүдийг гүйцэтгэх төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон байх;

4.2.6.эмнэлгийн анхны тусламжийн болон галын аюулаас хамгаалах цэг, ариун цэврийн шаардлага хангасан бие засах газар, хог хаягдлын цэг, үйлчилгээний байр, мэдээлэл, зааварчилгааны танхимтай байх;

4.2.7.шалгалтын үйлдэл гүйцэтгэхэд зориулсан талбайгаас тусдаа тээврийн хэрэгслийн зогсоолд зориулсан стандартын шаардлага хангасан талбайтай байх;

4.2.8.шалгалтыг хэвийн явагдах нөхцөлийг хангахуйц гэрэлтүүлэгтэй байх;

4.2.9.тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд зориулсан хэсэгт шалгалтын зорилгод хамааралгүй, шалгуулагчид саад болох эд зүйлс, тоног хэрэгсэл байрлуулаагүй байх.

4.3.Дадлагын шалгалтын үйлдлийг тэмдэглэсэн чиглүүлэх хэрэгслийг хяналтын автомат төхөөрөмжөөр тоногдсон байж болно. Талбайн шалгалтын үйлдлийг буруу гүйцэтгэсэн тохиолдолд мэдээлэл өгөх зориулалт бүхий дохиоллын системтэй байна.

4.4.Дадлагын шалгалтын тусгай талбай нь шалгагчийн ажиглах байртай байна. Ажиглах байр нь шалгах бүрэлдэхүүний ажиллах нөхцөлийг бүрэн хангасан байхаас гадна шалгалтын талбайг бүхэлд нь харж хянах боломжтой байхаар байрласан байна.

4.5.Шалгалтын тусгай талбайг дүрс бичлэгийн хяналтын төхөөрөмж (камер) болон дохиолол, холбоо, чанга яригч хэрэгслээр тоноглоно. Чанга яригч хэрэгслийг шалгагчийн ажиглах байрнаас удирдах боломжтой байна.

Тав. Шалгалтад ашиглах тээврийн хэрэгсэлд тавих шаардлага

5.1.Шалгалтын төв нь дадлагын шалгалт авахад зориулсан түрээсийн эсхүл өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгсэлтэй байна.

5.1.1."B" ангилалд 5-аас доошгүй;

5.1.2."C" ангилалд 2-оос доошгүй;

5.1.3."D" ангилалд 2-оос доошгүй;

5.1.4."E" ангилалд 1-ээс доошгүй;

5.1.5."A" ангилалд 3-аас доошгүй;

5.1.6."M" ангилалд 1-ээс доошгүй.

5.2.Шалгуулагч нь дадлагын шалгалтыг шалгалтын төвийн тээврийн хэрэгсэл, эсвэл энэ журамд нийцсэн, стандартын шаардлага хангасан бусад тээврийн хэрэгслээр өгч болно.

5.3.Жолоодлогын дадлагын эхний талбайн шалгалтад ашиглах тээврийн хэрэгсэл нь дараах шаардлагыг хангасан байна.

5.3.1.техникийн хяналтын үзлэгт тэнцсэн;

5.3.2.Замын хөдөлгөөний дүрэмд заасан ашиглахыг хориглох эвдрэл, гэмтэл, техникийн зөрчилгүй;

5.3.3.зүүн гар талдаа жолооны хүрдтэй, механик буюу автомат дамжуулга бүхий хурдны хайрцагтай.

5.4.Замын хөдөлгөөний шалгалтад ашиглах тээврийн хэрэгсэл нь энэхүү журмын 5.3-д заасан шаардлагаас гадна мөн дараах шаардлагыг хангасан байна:

5.4.1.шалгагчид зориулсан тоормосны нэмэлт дөрөө, ар талыг харах нэмэлт тольтой;

5.4.2.Замын хөдөлгөөний дүрэмд заасан "Сургалтын тээврийн хэрэгсэл" таних тэмдэгтэй.

5.5.Хөгжлийн бэрхшээлтэй шалгуулагчийн шалгалт өгөх тээврийн хэрэгсэл нь баруун гар талдаа жолооны хүрдтэй байж болох бөгөөд Замын хөдөлгөөний дүрэмд заасан "Тахир дутуу хүн" таних тэмдгийг байрлуулсан байна.

5.6.Жолоодлогын дадлагын шалгалтад дараах техникийн үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийг ашиглана.

5.6.1."А" ангилалд хоёр дугуйтай мотоцикл;

5.6.2."В" ангилалд суудлын автомашин;

5.6.3."С" ангилалд бүх жин нь 7500 кг-аас их ачааны автомашин;

5.6.4."D" ангилалд 8 м-ээс багагүй урттай автобус;

5.6.5."BE" ангилалд бүх жин нь 1000 кг-аас доошгүй чиргүүлтэй "В" ангиллын автомашин;

5.6.6."CE" ангилалд авто чирэгч, хоёр тэнхлэгтэй (тэнхлэгүүдийн хоорондын зай нь 1 м-ээс багагүй) чиргүүл бүхий бүх жин нь 7500 кг-аас их ачааны автомашин;

5.6.7."DE" ангилалд угсраа автобус буюу бүх жин нь 1000 кг-аас доошгүй чиргүүл бүхий 8 м-ээс багагүй урттай автобус;

5.6.8."M" ангилалд 41 квт-аас дээш чадалтай хөдөлгүүр бүхий дугуйт трактор;

5.7.Шалгалтад ашиглах тээврийн хэрэгслийн бүхээг дээр хугацаа хэмжүүрийн төхөөрөмж байрлуулж болох бөгөөд уг төхөөрөмж нь хугацаа дууссан тохиолдолд мэдээлэл өгөх горимоор ажилладаг гэрлэн дохиололтой байж болно.

Зургаа.Бусад

6.1.Шалгалтын төв нь шалгалтад хамрагдаж буй иргэдийн мэдээллийг нэгтгэн боловсруулах мэдээлийн сантай байна. Мэдээллийн сан нь Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сан, жолоочийн бүртгэл мэдээллийн сан, Үндэсний дата төв, холбогдох мэдээлийн сангуудтай уялдан ажиллаж, харилцан мэдээлэл солилцох боломжтой байна.

6.2.Шалгуулагч нь өөрт олгогдсон бүртгэлийн дугаар /код/-ыг ашиглан холбогдох сайт, ухаалаг утсанд зориулсан программ хангамж, лавлах утас, мессеж үйлчилгээ зэрэг мэдээллийн хэрэгслийг ашиглан шалгалтын үр дүн, хуваарь, зааврын талаарх мэдээллийг авах боломжоор хангагдсан байна.

6.3.Шалгуулагчдад шалгалтын хуваарь, холбогдох мэдээллийг цахим болон утсан холбоогоор хэлбэрээр ажлын 3-аас доошгүй өдрийн өмнө хүргэх ажлыг Шалгалтын төв хариуцна.

6.4.Энэхүү журмыг зөрчсөн шалгагч, шалгуулагчид холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

ТАНИЛЦУУЛГА

Шинэчлэн батлагдсан Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэгт "Жолоодох эрхийн шалгалтын төвийн үйл ажиллагааны болон жолоодох эрхийн шалгалт авах журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална" гэж заасны дагуу "Жолоодох эрхийн шалгалтын төвийн үйл ажиллагааны журам"-ыг шинэчлэн боловсрууллаа.

Механикжсан тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх асуудал нь хүний өдөр тутмын хэрэгцээнд чиглэхээс гадна мэргэжлийн чиглэлээр ажиллах боломжийг бүрдүүлж байгаа юм. Одоогийн мөрдөж буй хууль тогтоомжоор тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалт, шалгалт авах, үнэмлэх олгох үйл ажиллагааг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмын дагуу цагдаагийн байгууллага эрхлэн хариуцаж байгаа.

Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалт нь Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 14.4-т заасан мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх богино хугацааны түр сургалтад хамаарах тул уг хуулийн дагуу жолооч бэлтгэх асуудлыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцах нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 14-т заасан Хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд бүрэн нийцэж байна..

Онолын мэдлэгийг иргэн бие дааж сурч болох, аюулгүй байдлын үүднээс дадлагыг заавал танхим, талбайд гүйцэтгэж сурдаг байх, шалгалтыг мэдлэг, дадал чадварыг эзэмшсэн иргэн боломжтой үедээ өгдөг байхаар шинэчилсэн хуулинд тусгасан.

Журмын төслийг боловсруулахдаа Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль/шинэчилсэн найруулга/-ийн зохицуулалтыг баримтлан, Хууль зүйн сайдын 2014 оны А/158 тоот тушаалаар батлагдсан "Тээврийн хэрэгслийн жолоочоос мэргэжлийн шалгалт авах, үнэмлэх олгох журам"-аар зохицуулж байсан зарим харилцааг тусган, орчин үеийн техник хэрэгслийн дэвшлийг ашиглах асуудлыг тусгахад анхаарсан.

Манай улсын нийгэм, эдийн засгийн байдалтай холбогдуулан одоо жолоочийн мэргэжлийн сургалт явуулж буй байгууллагаас сонгон шалгаруулах замаар шалгалтын төвийг хувийн хэвшлийн хөрөнгөөр барьж байгуулах боломжтой. Мөн төсөлд хуулиар нарийвчлан зохицуулаагүй зарим харилцаа болох шалгалтын төвийн хураамжийн хэмжээ, шалгалтын төв ажиллуулах эрх олгох, дуусгавар болохтой холбогдсон харилцааг зохицуулахаар тусгасан болно.

Шалгалтын төвийн үйл ажиллагаанд Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, бүсийн арга зүйн төв, Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагууд Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран байнгын хяналтыг тавих нөхцлөөр хангах зорилгоор ЦЕГ-ын дарга буюу түүний эрх шилжүүлсэн албан тушаалтантай гэрээ хийх, шалгалтын төвийн техник хэрэгсэл, танхим, талбайд тавигдах шаардлагыг стандартаар тогтоохоор хуульчилсан тул уг стандартад тусгагдвал зохих ерөнхий шаардлагуудыг мөн журмын төсөлд оруулсан.

Шалгалтын төв нь тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтад хамрагдан, шалгалтуудад тэнцсэн тохиолдолд үнэмлэхийг шууд хэвлэж олгодог байх шаардлагыг хангахын тулд эхний ээлжинд Лицензийн төвөөс хэвлэгдсэн үнэмлэхийг иргэд, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчид хүлээлгэж өгөх үүрэг хүлээхээр журамд тусгасан.

Цаашид энэхүү журмын төслийг өөрчлөх тохиолдолд манай улсын нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан төсөв, хөрөнгийг хэрхэн шийдвэрлэх, төрийн зүгээс ямар зохицуулалт хийх, ямар ажлыг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх талаар практик, судалгаа болон чиг үүргийн албадын саналыг авсны дараа шийдвэр гаргахыг санал болгож байна.

Шинэчлэн боловсруулсан журмын төсөл нь 7 бүлэгтэй бөгөөд нийтлэг үндэслэл, шалгалтын төвд тавигдах шаардлага, шалгалт авах ажиллагаа хориглох зүйл болон бусад асуудлыг тус тус тусгаж өгсөн.

Төслийг боловсруулахдаа Цагдаагийн байгууллагаас төлөвлөж байгаа зарим онцлог ажил, арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхэд дөхөмтэй байдлуудыг харгалзан мэргэжлийн харъяа албад, алба хаагчдын саналыг авч нэгтгэсэн.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэгт заасны дагуу "Жолоодох эрхийн шалгалт авах журам"-ыг мэргэжлийн боловсрол, сургалтын болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтран батлах "Жолоодох эрхийн шалгалтын төвийн үйл ажиллаганы журам"-ын төсөл, танилцуулгыг боловсруулж хүргүүлэв.

Журмыг батлахад Хууль зүйн сайдын 2014 оны А/158 дугаар тушаалыг хүчингүй болгох шаардлагатай болно.

----oOo----